

## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР 2024 ОНД ХИЙЖ, ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Нэг. Эрх зүйн маргаан, хэрэг шийдвэрлэлтийн байдал

### 1.1. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай

Нийслэлийн өмчийн харилцааны газрыг төлөөлж оролцсон 3 хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн бол Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлыг төлөөлж оролцож буй 1 хэрэг, Нийслэлийн Засаг даргыг төлөөлж оролцож буй 2 хэрэг, байгууллагыг төлөөлж оролцож буй 5 хэрэг нийт 8 хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байна.

#### 1.1.1. Төлөөлөгчөөр оролцон шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хэрэг:

№	Нэхэмжлэгч	Хариуцагч	Шүүх, шүүгч	Нэхэмжлэлийн шаардлага	Тайлбар
1	"Бигмайнд Бюлдинг" ХХК	НӨХГ, УСУГ	СБД-ийн ИХАШШ Б.Мөнхзул	"Солонго" орон сууцны хорооллын гаднах цэвэр усны шугам, бохир усны гол шугамын хамтран өмчлөгчөөр тогтоолгох;	2024.04.17-ны өдөр анхан шатны шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. 2024.09.18-ны өдөр давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.
2	Иргэн Г.Мөнхсайхан	НӨХГ	ЗХАШШ С.Ганбат	Төрийн албанаас түр чөлөөлсөн тушаал гаргахгүй байгаа эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоолгох, төрийн албанаас түр чөлөөлсөн тушаал гаргахыг даалгах;	2024.05.27-ны өдөр анхан шатны шүүхээс нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, зарим хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Шүүхийн шийдвэр бичгээр гармагц давж заалдах гомдол гаргахаар ажиллаж байна.
3	"Алаг даага" ХХК нарын 10 байгууллага	НӨХГ	ЗХАШШ Д.Халиуна	НӨХГ-ын 1/1223 дугаар албан бичгээр өгсөн мэдэгдлийг хүчингүй болгуулах НӨХГаас УБДС ТӨХК-д хүргүүлсэн 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 1422 дугаар, НӨХГ-ын 1/1348 дугаартай "Урт цагаан үйлчилгээний төвийн барилгын цахилгааныг хязгаарлах тухай" албан бичиг болон	Нэхэмжлэгч нар нэхэмжлэлээс татгалзсанаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болсон.

				түүний дагуу цахилгаан хязгаарласан УБЦТС ТӨХК-ийн үйлдэл, УБДС-ийн улсын байцаагчийн албан шаардлагыг хууль бус болохыг тогтоож, цахилгаанаар хангахыг даалгах;	
--	--	--	--	--	--

1.1.2. Төлөөлөгчөөр оролцож буй шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа хэрэг:

№	Нэхэмжлэгч	Хариуцагч	Шүүх	Нэхэмжлэлийн шаардлага	Тайлбар
Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлыг төлөөлж оролцож буй хэрэг					
1	“Хар Чоног” ХХК	НИТХ	НИХДЭШШ	Урт цагаан үйлчилгээний төвийн 5-р корпус оруулсан хөрөнгө оруулалтын төлбөр 1,480,081,000 төгрөг гаргуулах;	Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2023.04.09-ний өдрийн 1483 дугаар шийдвэрээр НИТХ-аас 1,023,387,350 төгрөгийг гаргуулж нэхэмжлэгчид олгож, нэхэмжлэгчийн 456,693,650 төгрөгийн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. НӨХГ-аас анхан шатны шүүх хуралд оролцоогүй. Анхан шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэгдсэний дараа итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилсон бөгөөд давж заалдах гомдол гаргаад байна.
Нийслэлийн Засаг даргыг төлөөлж оролцож буй хэрэг					
2	“Алаг даага” ХХК нарын /10 байгууллага/	НИТХ, НЗДарга	ЗХАШШ Д.Халиуна	1.НИТХ-ын 11/65 тогтоолын нэхэмжлэгч нарт холбогдох хэсгийг биелүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулж, хувьчлаагүй эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоолгох; 2.“НЗД-ын А/216 дугаар захирамжийг хууль бус	1.Анхан шатны шүүхийн 2022.11.23-ны өдрийн 0173 тогтоолоор нэхэмжлэлийг буцааж шийдвэрлэсэн. 2.Нэхэмжлэгч нар 2023.01.16-ны өдөр тус шаардлагаар дахин нэхэмжлэл гаргасан.

				байсан болохыг тогтоолгох”, 3.“НИТХ-ын 129 дугаар тогтоолыг хууль бус байсан болохыг тогтоолгох;	3.Нийслэлийн Засаг даргын А/216 дугаар захирамжийг түдгэлзүүлэх хүсэлт гаргаж Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2023.03.15-ны өдрийн 2486 дугаар шүүгчийн захирамжаар захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж шийдвэрлэсэн. Давж заалдах шатны шүүх тус шийдвэрийг хэвээр үлдээсэн.  4.”Угалзат дархан” ХХК-аас 2024.01.24-ний өдөр нэхэмжлэлийн шаардлагаа өөрчилсөн.  Анхан шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байна.
3	“ЭХБУТ” ТӨХК	НЗДарга	ЧД-ийн ИХАШШ Дагдэчмаа	Гэм хорын хохиролд 806,000,000 төгрөг гаргуулах;	Анхан шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байна.
Нийслэлийн Өмчийн харилцааны газрыг төлөөлж оролцож буй хэрэг					
4	НӨХГ	Б.Ганцогт	ХУД-ын ИХАШШ Д.Хулан	Нийслэлийн өмчийн байрыг албадан чөлөөлүүлэх, түрээсийн төлбөрт 16,164,000 төгрөг, алданги 2,462,400 төгрөг, олох байсан орлого 30,744,000 төгрөг, нийт 49,370,400 төгрөгийг гаргуулах;	1.ХУД-ийн ИХАШШ-ийн 2021.12.10-ны 2905 дугаар шийдвэрээр түрээсийн гэрээний үүрэгт 25,806,600 төгрөг гаргуулж, байрнаас албадан чөлөөлүүлэх нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож, сөрөг нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн авахаас татгалзсан. 2.Давж заалдах шатны 2022.03.18-ны 500 дугаар

					<p>магадлалаар анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан.</p> <p>3.ХУД-ийн ИХАШШ-ийн 2022.06.13-ны 1898 дугаар шийдвэрээр үндсэн нэхэмжлэлээс 9,720,000 төгрөг, сөрөг нэхэмжлэлийн шаардлагаас 80,000,000 төгрөгийг гаргуулахаар шийдэж, харилцан тооцож нэхэмжлэгчээс 70,280,000 төгрөгийг гаргуулан хариуцагчид олгохоор шийдвэрлэсэн.</p> <p>4.Давж заалдах шатны шүүхийн 2022.09.02-ны 1644 дугаар магадлалаар дээрх шийдвэрийг хүчингүй болгож хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаасан. Анхан шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байна.</p>
5	“Материал Импекс” ХК	НӨХГ	СБД-ийн ИХАШШ Түмэнцэцэг	<p>2013.06.14-ний өдрийн 2013/33 дугаар гэрээг хүчин төгөлдөр бус байх хэлцэлд тооцуулж, хэлцлээр шилжүүлсэн үл хөдлөх эд хөрөнгийг “Материал Импекс” ХК-ийн өмчлөлд буцаан шилжүүлэхийг даалгах;</p>	<p>Анхан шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байна.</p>
6	НӨХГ	“Улаанбаатар Радио” ХХК	ЧД-ийн ИХАШШ Цэнд-Аюуш	<p>Нийслэлийн барилгаас өмчийн албадан гаргуулах;</p>	<p>ЧД-ийн ИХАШШ-ийн 2024.07.22-ны өдрийн 182/ШШ2024/03112 дугаар шийдвэр, НИХ-ийн ДЗШШ-ийн 2024.09.09-ний өдрийн 210/МА2024/01734 дугаар магадлалаар нэхэмжлэлийн</p>

					шаардлагыг тус тус хангаж шийдвэрлэсэн. Хариуцагч “Улаанбаатар радио” ХХК нь 2024.10.07-ны өдөр хяналтын журмаар Улсын дээд шүүхэд гомдол гаргасан тул энэхүү хэрэг нь тус шүүхэд хянагдаж байна.
7	“Анома” ХХК	НИТХ, НӨХГ	УДШ Н.Батчимэг	<p>Үндсэн нэхэмжлэлийн шаардлага: Урт цагаан Үйлчилгээний төвийн 2, 3 дугаар блокийн барилгад хийсэн засан сайжруулалтын зардлыг эд хөрөнгийг буцааж өгөх үеийн үнэлгээ 4,095,780,949 төгрөг гаргуулах;</p> <p>Сөрөг нэхэмжлэлийн шаардлага: 2013-2019 оны түрээсийн төлбөр 752,937,000 төгрөг, алданги 396,468,500 төгрөг, нийт 1,129,405,500 төгрөг гаргуулах;</p>	<p>Тус маргааныг ЧД-ийн ИХАШШ-ийн 2020.05.26-ны өдрийн 1239 дүгээр шийдвэр, давж заалдах шатны шүүхийн 2020.09.07-ны 1900 дүгээр магадлал, дээд шүүхийн 2022.09.22-ны өдрийн 0839 дүгээр тогтоолоор тус тус шийдвэрлэсэн.</p> <p>Нэхэмжлэгч 2023.09.25-ны өдөр шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг дахин хянуулах хүсэлт гаргасан бөгөөд УДШ-ийн 2023.11.07-ны өдрийн 0059 дүгээр тогтоолоор хүсэлтийг хангахаас татгалзаж шийдвэрлэсэн.</p> <p>Улмаар нэхэмжлэгч Үндсэн хуулийн цэцэд 2024.03.22-ны өдөр гомдол гаргаж, Үндсэн хуулийн цэцээс шийдвэрийг хуулийн дагуу хянан хэлэлцэж, шийдвэрийг иргэнд мэдэгдэх талаар УДШ-д мэдэгдсэн. УДШ-ын 2024.05.28-ны өдрийн хуралдаанаар УДШ-ийн 2022.09.22-ны 0839 дүгээр тогтоолыг хүчингүй болгож, тус хэргийг дахин</p>

					хэлэлцэхээр шийдвэрлэсэн.
8	“Улаанбаа тар радио” ХХК	НӨХГ	СБД-ийн ИХАШШ Н.Оюунтуяа	1.Чингэлтэй дүүргийн 5-р хороо, Баруун сэлбэ үйлчилгээний төвийн “Ж” блокийн 1222 м.кв талбай бүхий үл хөдлөх, эд хөрөнгийн хувьчлалд төлсөн үнэ 2,093,731,872 төгрөгийг гаргуулах; 2. Чингэлтэй дүүргийн 5-р хорооны нутаг дэвсгэрт байрлах 1500601472 нэгж талбарын дугаартай, эрхийн улсын бүртгэлийн Э-2202004526 дугаарт бүртгэлтэй 1542 м.кв газрыг албадан чөлөөлүүлэх;	2024.12.13-ны өдөр хэрэг үүссэн.

1.2. Бусад хууль хяналтын байгууллагад мөрдөн шалгах ажиллагаанд байгаа хэрэг:

1.2.1. “Төв цэнгэлдэх хүрээлэн” ХХК-ийн хувьцаа эзэмшилтэй холбоотой асуудлаар Улсын бүртгэлийн ерөнхий газарт 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 1/554 дугаар албан бичгээр гомдол гаргасан. Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2024 оны 04 сарын 22-ны өдрийн 1/5268 дугаарт албан бичгээр хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд “Төв цэнгэлдэх хүрээлэн” ХХК-ийн 100 хувийн хувьцаа эзэмшигчээр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал 2024 оны 04 сарын 18-ны өдөр бүртгэгдсэн талаар хариуг ирүүлсэн байна.

1.2.2. Тус газрын балансад бүртгэлтэй, нийслэлийн өмч болох 14 объектой холбоотойгоор өмчлөл, эзэмшлийн асуудлыг шийдвэрлүүлж, хууль бус байж болзошгүй үйлдлийг шалгуулахаар Нийслэлийн Прокурорын газарт өргөдөл, гомдлыг гаргасан. Нийслэлийн Прокурорын газраас дараах асуудлуудыг Авлигын эсрэг гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй байдлыг шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн бөгөөд мөрдөн шалгах ажиллагаа явагдаж байна. Тус газарт 2024 оны 06 сарын 19-ний өдрийн 4/1102, 2024 оны 06 сарын 25-ны өдрийн 4/1146, 4/1147, 4/1149 дугаарт албан бичгээр нотлох баримт хүргүүлэн ажилласан. Мөн Хяналтын шалгалтын хэлтсийн дарга болон зарим албан хаагчдаас хэд хэдэн удаагийн мэдүүлэг авсан. Үүнд:

- Нийслэлийн өмчийн барилга болох Сүхбаатар дүүргийн 2 дугаар хороо, 1а байрны 1 тоотод байрлах өрхийн эмнэлгийн байрыг “Ачит гар” өрхийн эмнэлэг нь “Өмч эзэмшлийн гэрээ”-ээр үнэ төлбөргүй, хууль бусаар эзэмшиж, ашиглаж байсан бөгөөд байрны хийц бүтээцийг зөвшөөрөлгүй өөрчилсөн, байр чөлөөлөхөөс үндэслэлгүй татгалзсан үйлдэл;

- Монголын Бурхан Шашинтны шинэ төвийн тэргүүн С.Санждорж нь Сүхбаатар дүүргийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Дамбадаржайлин хийдийн Цогчин дуган А, Б, В блокод Нийслэлийн Өмчийн харилцааны газартай 2010.12.13-2013.12.13, 2014.08.02-2015.08.25-ны хооронд “Нийслэлийн өмчийн барилгад их засвар, хөрөнгө оруулалт хийлгэх тухай байгуулсан гэрээ” гэх гэрээ байгуулж, хөрөнгө оруулалт (засан сайжруулалт) хийсэн бөгөөд барилгыг чөлөөлж, хүлээлгэн өгөхөөс үндэслэлгүй татгалзсан үйлдэл;
  - Баянгол дүүрэг, 7-р хороо, “Эрхэм жаргалан” өрхийн эрүүл мэндийн төвийн хуучин барилга болон Баянгол дүүрэг, 14-р хороо Москва рестораны баруун талд байрлах объектыг тус тус “Тэмүүжин групп” ХХК-д эзэмшүүлж, ашиглуулсан, давхар түрээслэж ашиг олсон үйлдэл;
  - Ерөнхий сайд Жигжид-жавын байранд “Монгол Улсын Нутгийн удирдлагуудын холбоо” ТББ гэрээгүйгээр үйл ажиллагаа явуулдаг асуудалд;
  - Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийг Ж.Хатанбаатарт менежментийн гэрээгээр хувьчлахаар гэрээ байгуулж, үйл ажиллагаа явуулсан, нийслэлийн өмчүүдийг эзэмшүүлсэн асуудалд;
  - Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо “Монгол шуудан” ХК-ийн 36 дугаар салбарын байр нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 02/13 дугаар тогтоолоор өмч хувьчлах жагсаалтад орсон ч хувьчлагдаагүй байна. Гэтэл Нийслэлийн өмчийн газрын балансаас ямар нэг шийдвэргүйгээр хасагдсан байгаа нь холбогдох хууль, журам зөрчсөн байдал;
  - Сүхбаатар дүүрэг, 7-р хороо, 11-р хороолол, 6-р байр, 2-р орц 40 тоот орон сууцыг Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын 2016.02.02-ны өдрийн 6/1447 дугаар албан бичгээр Ү-2203012059 дугаартайгаар С.Жамъянжав (ЧВ60062316)-ын өмчлөлд анх төрөөс хувьчилсан. 2005.01.12-ны өдрийн 05 дугаартай нотариатчийн гэрчилсэн Бэлэглэх гэрээгээр иргэн Ш.Дашжамц, Ш.Базарваань нарын өмчлөлд шилжсэн хариу ирсэн. Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо, Хүнсчдийн гудамжны 3А, Орбитын орон сууцны дунд байрлах 1 давхар тоосгон барилгын газар болон үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ иргэн С.Батчулууны нэр дээр гарсан. Сонгинохайрхан дүүрэг, 14-р хороо, 1-р хороолол, 14-8-253 тоот орон сууцыг иргэн О.Сүрэнхорлоо Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн Ү-2201020811 гэрчилгээгээр өмчилсөн байна. Баянгол дүүрэг, 14-р хороо, 3 хороолол 18-30 тоот орон сууцыг иргэн П.Цогтбаатар Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн Ү-2205082124 гэрчилгээгээр өмчилсөн нь холбогдох хууль, журам зөрчсөн үйлдэл;
  - Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, “Баруун сэлбэ” үйлчилгээний төвийн барилгын “Ж” блокийн зүүн жигүүрт байрлах 1226.96 м<sup>2</sup> талбайг “Улаанбаатар радио” ХХК-д эзэмшүүлсэн нь хууль, журам зөрчсөн үйлдэл;
  - “Нью тур сафарис” ХХК-д өр төлбөрт нийслэлийн өмчийн үнэ цэнэ бүхий объектуудыг өгсөн асуудлыг тус тус шалгаж байна.
- 1.2.3. Нийслэлийн Засаг даргын захирамжийн дагуу актлагдаж, данс бүртгэлээс хасагдсан зарим тээврийн хэрэгслүүдээс хоёрдогч түүхий эд буюу сэлбэгийн

зориулалтаар худалдан борлуулах тээврийн хэрэгслүүд нь замын хөдөлгөөнд оролцож байгаа болон гэмт хэргийн шинжтэй зарим асуудал байж болзошгүй байдлыг шалгуулахаар цагдаагийн газарт өргөдлийг гаргаж, шийдвэрлүүлсэн.

Хоёр. Хууль тогтоомж, дүрэм, журмын нэмэлт, өөрчлөлтөд санал боловсруулж хүргүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах тухай

2.1. Хууль тогтоомж, дүрэм, журмын нэмэлт, өөрчлөлтөд оруулах, санал боловсруулж хүргүүлсэн байдал:

- “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын төсөл;
- “Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн дүрэм”-ийн төсөл;
- “Тэтгэврийн нөөц санд хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, өвлүүлэх, хяналт тавих журам”-ын төсөл;
- “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх, нөөцийн санг ашиглах журам”-ын төсөл;
- “Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ын төсөл;
- “Төрийн албаны тэргүүний ажилтан цол, тэмдгээр шагнах журам”-ын төсөл;
- “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын төсөл;
- Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хуулийн төсөл;
- “Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан 8 стандартын төсөл;
- Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн төсөл;
- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 55 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг дүгнэх журам”, 65 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”, “түрээслэгчийг сонгон шалгаруулах журам”-д тус тус хяналт-шинжилгээ хийн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд хүргүүлсэн.
- Багахангай, Багануур, Налайх дүүргийн үйлдвэрлэл, технологийн паркуудын дүрмийн төслийг хянаж, санал өгсөн.
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн төсөл.

2.2. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажилласан байдал:

- Хөдөлмөрийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.3-т “Ажил олгогч эд хөрөнгийн бүрэн хариуцлага бүхий ажлын байрны жагсаалтыг батална” гэж заасны дагуу газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/81 дүгээр тушаалаар “Эд хөрөнгийн бүрэн хариуцлага бүхий албан тушаалын жагсаалт”-ыг батлуулж, “Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ”-ыг шинэчлэн боловсруулж, холбогдох албан хаагчидтай байгуулсан.



- Байгууллагын үйл ажиллагааг хангах зорилгоор батлан гаргаж байгаа бүх төрлийн баримт бичгийн (тушаал шийдвэр, албан бичиг, гэрээ, захирамжлалын баримт бичгийн төсөл гэх мэт) төслийг өдөр тутам хянаж, хууль зүйн үндэслэлийг зөв бичих, жигдрүүлэхэд анхаарч, албан хаагчдыг хууль зүйн зөвлөгөө мэдээллээр тогтмол ханган ажиллаж байна.
- Шинээр батлагдан гарсан хууль тогтоомж, дүрэм журмуудыг албан хаагчдад танилцуулах хуудсаар болон цахим системээр дамжуулан танилцуулсан.
- Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын төслийг шинэчлэн боловсруулсан.
- Дотоод, хяналт шалгалт зохион байгуулах журмын төслийг шинэчлэн боловсруулсан.
- Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журмын төслийг шинэчлэн боловсруулсан.

Гурав. Эрх зүйн чиглэлийн сургалт,  
хэлэлцүүлэгт хамрагдсан байдал.

Эрх зүйн чиглэлээр зохион байгуулагдсан дараах сургалт, хэлэлцүүлэгт хамрагдсан. Үүнд:

- Нийслэлийн хүний нөөцийн төвөөс зохион байгуулсан “Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн хэрэглээ, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” сургалтад 3 албан хаагч;
- “Жендерийн эрх тэгш байдлыг хангахад төрийн албан хаагчийн манлайлал оролцоо” сургалтад 5 албан хаагч;
- “Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа 2050” сургалтад 5 албан хаагч;
- “Хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөлт, тайлагналт хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй” сургалтад 2 албан хаагч;
- Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг шинэчлэн гаргах тухай, анхаарах асуудал” сэдэвт сургалтад нийт албан хаагч;
- Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар, Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвтэй хамтран зохион байгуулсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой “Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх” сургалтад 2 албан хаагч;
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль, дагалдан гарсан хууль тогтоомж болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн ойлголт олгох сургалтад 1 албан хаагч;
- Удирдлагын академиас зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сургалтад 2 албан хаагч;

- 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулагдсан Холбооны Бүгд Найрамдах Герман улсын Мьонхн хотын тойргийн даргын “Хот байгуулалт, төлөвлөлт, барилгын стандартын” талаарх лекцэд 1 албан хаагч;
- Компанийн засаглалын сургалтад 5 албан хаагч;
- Төрийн албаны зөвлөлөөс цахим хэлбэрээр зохион байгуулдаг 7:4:10 сургалтуудад тогтмол хамрагдсан;
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн хөгжил, хамгаалал” хэлэлцүүлэгт тус тус хамрагдсан;
- “Төрийн болон орон нутгийн өмчит компанийн шинэчлэл ба хөрөнгийн зах зээл” сэдэвт сургалтад газрын албан хаагчид бүрэн хамрагдсан;
- Авлигын эсрэг олон улсын өдөрт зориулсан сургалт;
- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдад зориулсан эрх зүйн сургалтад тус тус хамрагдсан.

---oOo---